ЮДЕНТАКС ТИН АУДИТ ХХК
АУДИТ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ, ТАТВАРЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

2021 он 01 сар 26 өдөр №01/08-ХХК Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"ТЭРХ КАПИТАЛ ББСБ" ХХК
Хувьцаа эзэмшигчдэд

Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан

Зөрчилгүй санал дүгнэлт

"Тэрх Капитал ББСБ" ХХК-ийн дараах тайлангуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2020 оны 12-р сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан,
- Энэ өдрөөрх жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд, болон
- Нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь компанийн 2020 оны 12-р сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)-ийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан санал дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон бидний аудиторын тайлан ордоггүй. Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Pro One оффис 704 тоот
Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол
Улаанбаатар хот 14201, Ш/х: 46/772
Монгол улс

Утас: 976-99088851
976-99111764
976-94024723
Факс: 976-77110981
И-мэйл: yudentax@gmail.com

Санхүүгийн тайлангийн аудиттайгаа холбогдуулан бидний хүлээх үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, ингэснээр бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитаар олж авсан бидний мэдлэг эсвэл өөр хэлбэрээр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх тухай материаллаг үл нийцэлтийг авч үзэхэд оршдог.

Бид өөрсдийн гүйцэтгэсэн ажил дээрээ суурилан энэхүү бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлтэй байна гэж дүгнэвэл тухайн бодит байдлыг тайлагнахыг биднээс шаарддаг. Бидэнд ингэж тайлагнах зүйл байхгүй болно.

Санхүүгийн тайланд Удирдлага ба Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага
Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, болон алдаа юм уу залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь компанийг татан буулгах эсвэл үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага өөдрөг төсөөллөөр үйл ажиллагаагаа үргэжлүүлэх компанийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан болох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ.

Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага
Залилан эсвэл алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй баталгаажилтыг олж авч, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлж байна гэж амласан баталгаа гаргадаггүй.

Алдаа зөрчил нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд хэрэв тэр нь дангаараа эсвэл нийлэхээрээ санхүүгийн тайланд үндэслэн түүнийг хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Мөн бид:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс

ЮДЕНТАКС ТНП
АУДИТ ХХК
ХУУДАС 4

харьцангуй их байдаг. Учир нь залиланд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно. Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалдл тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.

- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын ул үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоон дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.
- Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхааа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг “Банк Бус Санхүүгийн Байгууллага”-ийн тухай Монгол улсад мөрдөгдөж буй хууль, дүрэм, заавар, журмын дагуу “Тэрх Капитал ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Э. НИНЖДУЛАМ
Юдентакс Тин Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот

Огноо: 2021.01.26

"ТЭРХ КАПИТАЛ ББСБ" ХХК
АУДИТЛАСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

(төгрөгөөр)

	Лав	**2020.12.31**	2019.12.31
ХӨРӨНГӨ			
Бэлэн мөнгө ба банк дахь мөнгөн хөрөнгө	*6*	1,082,291,234.36	1,236,898,476.49
Зээл ба урьдчилгаа, цэвэр	*7*	910,522,698.00	1,100,687,857.00
Бусад авлага		-	-
Бусад хөрөнгө		-	-
Урьдчилж төлсөн зардал, тооцоо		-	-
Үндсэн хөрөнгө, цэвэр	*8*	4,060,782.25	4,467,239.89
Биет бус хөрөнгө, цэвэр		-	-
Нийт хөрөнгийн дүн		**1,996,874,714.61**	**2,342,053,573.38**
ӨР ТӨЛБӨР			
Татвар, шимтгэлийн өглөг	*9*	494,421.56	8,622,112.55
Бусад өглөг		-	-
Банкнаас авсан зээл		-	-
Нийт өр төлбөр		**494,421.56**	**8,622,112.55**
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ			
Хувьцаат капитал	*10*	1,500,000,000.00	1,500,000,000.00
Нэмж төлөгдсөн капитал	*11*	20,000.00	20,000.00
Дахин үнэлгээний нэмэгдэл		-	-
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	*12*	496,360,293.05	833,411,460.83
Нийт эзэмшигчдийн өмч		**1,996,380,293.05**	**2,333,431,460.83**
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		**1,996,874,714.61**	**2,342,053,573.38**
		-	-

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно

ЮДЕНТАКС ТӨҮГ
АУДИТ ХКК
ХУУДАС 6

"ТЭРХ КАПИТАЛ ББСБ" ХХК
АУДИТЛАСАН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

(төгрөгөөр)

	Лав	**2020.12.31**	2019.12.31
Хүүний орлого		248,938,205.00	281,041,089.00
Хүүний орлогын буцаалт		-	-
Хүүний зардал		-	-
Цэвэр хүүгийн орлого	*13*	**248,938,205.00**	**281,041,089.00**
Харилцахын хүүний орлого		156,707,894.41	149,973,024.13
Бусад хүүний орлого	*13*	**156,707,894.41**	**149,973,024.13**
Гадаад валютын арилжааны орлого		-	-
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	*14*	6,353,000.00	18,749,750.00
Бусад үйлчилгээний орлого		-	-
Хүүний бус цэвэр орлого		**6,353,000.00**	**18,749,750.00**
Үйл ажиллагааны орлого		**411,999,099.41**	**449,763,863.13**
Үйл ажиллагааны зардал	*15*	39,135,114.86	43,484,453.30
Үйл ажиллагааны ашиг		**372,863,984.55**	**406,279,409.83**
Үйл ажиллагааны бус орлого	*16*	3,793,037.18	3,340,539.00
Үйл ажиллагааны бус зардал		-	-
Орлогын татварын өмнөх ашиг		**376,657,021.73**	**409,619,948.83**
Орлогын татварын зардал		21,489,300.62	40,961,994.87
Цэвэр ашиг (алдагдал)		**355,167,721.11**	**368,657,953.96**

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно

ЮДЕНТАКС ТӨК
АУДИТ ХХК
ХУУДАС 7

"ТЭРХ КАПИТАЛ ББСБ" ХХК
АУДИТЛАСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Өмчийн дүн
2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	**1,500,000,000.00**	**20,000.00**	**-**	**464,753,506.87**	**1,964,773,506.87**
Хувьцаат капиталын өсөлт					
Дахин үнэлгээний цэвэр өсөлт (бууралт)					
Хуваарилсан ноогдол ашиг					-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				368,657,953.96	368,657,953.96
2019 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	**1,500,000,000.00**	**20,000.00**	**-**	**833,411,460.83**	**2,333,431,460.83**
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-	-
Залруулсан үлдэгдэл	**1,500,000,000.00**	**20,000.00**	**-**	**833,411,460.83**	**2,333,431,460.83**
Хувьцаат капиталын өсөлт					
Дахин үнэлгээний цэвэр өсөлт (бууралт)					
Хуваарилсан ноогдол ашиг				(692,218,888.89)	(692,218,888.89)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				355,167,721.11	355,167,721.11
2020 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	**1,500,000,000.00**	**20,000.00**	**-**	**496,360,293.05**	**1,996,380,293.05**
					-

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно



"ТЭРХ КАПИТАЛ ББСБ" ХХК
АУДИТЛАСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жил

(төгрөгөөр)

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ:	2020.12.31	2019.12.31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	**1,465,291,480.41**	**1,588,243,746.13**
Зээлийн хүүний орлого	1,305,603,364.00	1,423,355,972.00
Харилцах дансны хүүний орлого	156,707,894.41	149,973,024.13
Гадаад валютын арилжааны орлого		
Гадаад валютын ханшийн зөрүү		
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	2,261,000.00	6,794,750.00
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	719,222.00	8,120,000.00
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	**999,029,951.54**	**1,588,590,089.57**
Үндсэн ба нэмэгдэл цалин	22,562,525.96	21,219,587.98
Төлсөн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал	72,431,140.97	7,899,415.91
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	1,550,000.00	1,860,000.00
Шатахуун, холбоо, интернэт, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	914,000.00	1,211,400.00
Бичиг хэрэг, ариун цэврийн зардалд төлсөн мөнгө	1,159,585.00	421,700.00
Татвар, даатгалын төлсөн мөнгө	30,066,991.61	38,448,550.68
Зар, суртчилгаанд төлсөн мөнгө	-	768,000.00
Мэргэжлийн зөвөлгөө үйлчилгээний төлбөр	1,100,000.00	1,100,000.00
Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	3,005,920.00	1,980,000.00
Банкны нийлүүлэгчид төлсөн мөнгө (Зээл олголт)	862,408,000.00	1,500,645,000.00
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	3,831,788.00	13,036,435.00
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**466,261,528.87**	**(346,343.44)**
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	2,128,229.00	3,340,539.00
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Гаргасан хувьцаа /дүрмийн сан нэмэгдүүлсэн/		
Бусад орлого	2,128,229.00	3,340,539.00
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	622,997,000.00	-
Төлсөн ноогдол ашиг	622,997,000.00	-
Банк ёслол, зочин төлөөлөгчийн зардал		
Бусад		
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	**(154,607,242.13)**	**2,994,195.56**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,236,898,476.49	1,233,904,280.93
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,082,291,234.36	1,236,898,476.49
	-	(0.00)

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно

ЮДЕНТАКС ТӨК
АУДИТ ХХК
ХУУДАС 9